**ТӨВ АЙМАГ**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 16 өдөр Дугаар А/286 Зуунмод

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, 66 дугаар зүйлийн 66.1, 78 дугаар зүйлийн 78.1, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 7 дугаар хуралдааны 03 тоот тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумдын орон нутгийн сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн улс төрийн албан хаагчдын тэтгэмжид шаардагдах 17,567,800 (арван долоон сая таван зуун жаран долоон мянга найман зуу) төгрөгийг хавсралт ёсоор баталж, аймгийн хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т зөвшөөрсүгэй.

2. Уг тэтгэмжид зарцуулах хөрөнгийг сумын Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан, холбогдох хүмүүст олгохыг сумын Төсвийн ерөнхийлөн захирагч Засаг дарга нарт даалгасугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (С.Магнайбаяр)-т хариуцуулсугай.

ЗАСАГ ДАРГА Д.МӨНХБААТАР

ТӨРИЙН САН
МЭРГЭЖИЛТЭН 266

Б. Оюунчимэг.
Санхүүжүүлэх.

Аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар
сарын 16 -ны өдрийн А/286 дугаар
захирамжийн хавсралт

ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН ҮР ДҮНГЭЭР ЧӨЛӨӨЛӨГДСӨН
УЛС ТӨРИЙН АЛБАН ТУШААЛТАНД ОЛГОХ ТЭТГЭМЖ

| № | Сумын нэр | Албан тушаал | Овог нэр | Үндсэн цалин | Сар | Нийт тэтгэмж |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Зуунмод | Багийн Засаг дарга | Б.Жигмэддорж | 697,388 | 6 | 4184.3 |
| 2 | | Багийн Засаг дарга | С.Очирбат | 697,388 | 6 | 4184.3 |
| 3 | Баянчандмань | Засаг даргын орлогч | Э.Энхболд | 853,200 | 6 | 5119.2 |
| 4 | Баянхангай | Багийн Засаг дарга | Д.Гэрэлчимэг | 680,000 | 6 | 4080.0 |
| | Дүн | | | | | 17567.8 |

ТӨРИЙН САН
МЭРГЭЖИЛТЭН 266

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС